



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/5

Улаанбаатар хот

Г “Ажил танилцуулах-Туршлага солилцох”  
өдөр”-ийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33,5 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх, түргэн шуурхай хүртээмжтэй болгох, биеийн тамир, спортын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, харилцан суралцаж туршлага солилцох зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооноос дүүргийн Биеийн тамир, спортын хороодтой хамтран “Ажил танилцуулах-Туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулсугай.
- 2.“Ажил танилцуулах-Туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулах хуваарийг хавсралтаар баталсугай.
3. Дээрх ажлыг тогтмол зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн /Г.Бямбасайхан/-д даалгасугай.



Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны  
даргын 2017 оны 03. дугаар сарын 13 өдрийн  
11/15 дугаар тушаалын хавсралт

Нийслэлийн нийтийн биеийн тамир,  
спортын хороо, дүүргүүдийн биеийн тамир, спорт хороодын  
“Ажил танилцуулах-туршлага солилцох өдөр”-ийг  
зохион байгуулах хуваар

| №  | Сарууд               | I | II | III | IY | Y | YI | YII | YIII | IX | X | XI | XII |
|----|----------------------|---|----|-----|----|---|----|-----|------|----|---|----|-----|
| 1  | Нийслэлийн<br>ННБТСХ |   |    |     | X  | X | X  |     | X    | X  | X | X  |     |
| 2  | БГД                  |   |    |     | X  |   |    |     |      |    |   |    |     |
| 3  | БЗД                  |   |    |     |    |   | X  |     |      |    |   |    |     |
| 4  | БНД                  |   |    |     |    |   |    |     |      |    | X |    |     |
| 5  | БХД                  |   |    |     |    |   |    |     | X    |    |   |    |     |
| 6  | СХД                  |   |    |     |    |   |    |     |      |    | X |    |     |
| 7  | СБД                  |   |    |     |    |   |    |     |      |    |   | X  |     |
| 8  | ХУД                  |   |    |     |    |   |    |     |      |    |   |    | X   |
| 9  | ЧД                   |   |    |     |    |   | X  |     |      |    |   |    |     |
| 10 | НД                   |   |    |     |    |   |    |     |      | X  |   |    |     |

#### Тавигдах шаардлага:

1. Дүүргийн Биеийн тамир, спортын хороод “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийг нийслэлийн Биеийн тамир, спортын хорооноос батлагдсан хуваарийн дагуу тушаал, хөтөлбөр, төлөвлөгөө гарган чанарын өндөр төвшинд зохион байгуулж зурагжуулсан тайлан, бусад холбогдох материалуудыг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороонд ажлын 3 хоногт багтаан цахимаар болон албан тоотоор ирүүлнэ.

2.“Ажил танилцуулах-Туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулах байршилыг дүүргийн Биеийн тамир, спорт хороод өөрсдөө тогтооно.

3.“Ажил танилцуулах-Туршлага солилцох өдөр”-ийг тухайн дүүргийн Биеийн тамир, спорт хороо зохион байгуулахдаа Биеийн тамир, спорт хороонууд, спортын холбоод, спортын клубууд, эрүүл мэндийн нэгдэл, ТББ, болон бусад аж ахуй нэгж байгууллагуудын хамтлагуудыг оролцуулж хамтран ажиллаж өргөн олныг хамруулна.

4.Өмнөх онуудад дүүргүүдийн Биеийн тамир, спортын хорооноос зохион байгуулсан “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-ийн гол гол шинэлэг санаа, үр дүнд хүрсэн ажлуудыг туршлага болгон нэвтрүүлсэн байна.

5.Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийн 2017 оны зорилтыг хэрэгжүүлж байгаа онцлог, шинэлэг санаа, үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг олон нийтэд зурагт үзүүлэн, самбар, презентэйшн, бусад боломжтой нөхцөлөөр сурталчлан таниулна.

6.Байгууллагын болон биеийн тамир, спорт, чийрэгжилтийн үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагаатай холбоотой санал асуулга авч нэгтгэн дүгнэж үнэлэлт дүгнэлт өгч хэрэгжүүлэх санал боловсруулж үйл ажиллагаандaa тусгаж ажиллана.

7.Телевиз, сонин, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилж хамтарч ажилласан байна.

8.Тухайн дүүргийн Биеийн тамир, спорт хороо нь бусад дүүргийн Биеийн тамир, спорт хороодоос зохион байгуулж байгаа “Ажил танилцуулах, Туршлага солилцох өдөр”-т заавал төлөөлөл оролцуулна.

Тухайн Биеийн тамир, спорт хорооноос зохион байгуулсан “Ажил танилцуулах-Туршлага солилцох өдөр”-ийн нийт үнэлгээг 2017 оны байгууллагын ажил дүгнэх журамд оруулан тооцно.